Байгууллагаас авах авлага	17,774.97	47,759.14	29,984.17
Хувь хүмүүсээс авах авлага	7,008.51	9,146.09	2,137.58
Зээлийн авлага	899,091.54	563,372.62	-335,718.92
<b>Дүн</b>	<b>926,475.33</b>	<b>622830.29</b>	<b>-303,645.05</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тус сумын нийт авлагын 90.5 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Мөн Номундалай, Баян-Ойт, Шаргалжуут, Соогоо сейко сургуулиудад нэг бүр 9,950.0 мянган төгрөгийн үнэтэй ухаалаг самбарын нийт 39,800.0 мянган төгрөгийн авлага, төрийн албаны цалингийн нэгдсэн систем холбогдсонтой холбоотойгоор тооцооллын зөрүүнээс үүдэлтэй цалин, суутган, НДШ-ийн авлага тайлант онд үүссэн байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	560.4	370.0	(190.4)	0.1
Засаг даргын Тамгын газар	-	2,393.3	2,393.3	0.4
Шаргалжуут тосгон	-	24.6	24.6	0.0
Эрүүл мэндийн төв	880.3	-	(880.3)	-
Орон нутгийн хөгжлийн сан	-	3,779.0	3,779.0	0.6
Сум хөгжүүлэх сан	899,091.5	563,372.6	(335,718.9)	90.5
Номун далай сургууль	629.4	14,175.5	13,546.1	2.3
Номгон сургууль	9.6	1,444.4	1,434.8	0.2
Эрдэнэмандал сургууль	6,927.8	6,301.6	(626.2)	1.0
Шаргалжуут сургууль	-	9,885.0	9,885.0	1.6
Баян-Ойт сургууль	59.4	10,009.4	9,950.0	1.6
Япон сургууль	-	9,950.0	9,950.0	1.6
1-р цэцэрлэг	2,302.9	66.1	(2,236.7)	0.0
2-р цэцэрлэг	233.1	197.1	(36.0)	0.0
3-р цэцэрлэг	10,000.0	20.4	(9,979.6)	0.0
5-р цэцэрлэг	2,359.5	-	(2,359.5)	-
7-р цэцэрлэг	63.2	-	(63.2)	-
9-р цэцэрлэг	69.1	378.9	309.7	0.1
10-р цэцэрлэг	1,503.8	-	(1,503.8)	-
11-р цэцэрлэг	759.5	-	(759.5)	-
Шаргалжуут цэцэрлэг	0.5	-	(0.5)	-
13-р цэцэрлэг	994.3	-	(994.3)	-
14-р цэцэрлэг	30.9	12.6	(18.3)	0.0
16-р цэцэрлэг	-	449.7	449.7	0.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>926,475.3</b>	<b>622,830.3</b>	<b>(303,645.0)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын насжилтаар нь авч үзвэл Эрдэнэмандал ахлах сургуулийн 6301.6 мянган төгрөгийн авлага 2019 онд үүссэн бол сум хөгжүүлэх сангийн нийт авлагын 190,518.5 мянган төгрөг нь 2 жилийн насжилттай, 122,811.32 мянган төгрөг нь 3 жилийн насжилттай, 47,516.3 мянган төгрөг нь 4 жилийн насжилттай, 202,526.5 мянган төгрөг нь 5 буюу түүнээс дээш жилийн насжилттай авлага байна.

**3.5.3 БАРАА МАТЕРИАЛ**

Бараа материалын эхний үлдэгдэл 1737217.7 мянга, эцсийн үлдэгдэл 2074869.8 төгрөг болж, 337652.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	384,241.6	530,406.9	146,165.3
Эм боох материал	23,866.2	70,807.1	46,940.9
Бичиг хэргийн материал	74,046.3	72,459.7	-1,586.6
Аж ахуйн материал	281,667.5	323,541.6	41,874.1
Сэлбэг хэрэгсэл	11,812.5	10,525.4	-1,287.1
Түлш, шатах тослох материал	13,707.3	4,493.0	-9,214.3
Барилгын засварын материал	37,901.7	84,163.6	46,262.0
Хүнсний материал	55,858.5	13,227.9	-42,630.6
Бусад хангамжийн материал	811,058.9	832,922.3	21,863.4
Мал амьтад	9,089.0	5,474.0	-3,615.0
Нөөцийн бараа	33,968.3	126,848.3	92,880.0
<b>Дүн</b>	<b>1,737,217.7</b>	<b>2,074,869.8</b>	<b>337,652.1</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл урьд оноос 337652.1 мянган төгрөг буюу 19.4 хувиар өссөн нь төсвийн байгууллагууд Ковид-19 цар тахалтай холбоотой эм боох материал, тусгай зориулалтын материал дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөн мөн нөөцийн материал дансанд Эрдэм ахлах сургуулийн урсгал засварын зардал 92880.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	5,674.6	14,191.0	8,516.4	0.68
Засаг даргын Тамгын газар	82,978.9	111,654.0	28,675.1	5.38
Шаргалжуут тосгон	5,537.5	1,950.0	(3,587.5)	0.09
Эрүүл мэндийн төв	33,877.6	37,347.2	3,469.6	1.80
Орон нутгийн хөгжлийн сан	33,968.3	33,968.3	-	1.64
Номун далай сургууль	171,207.4	185,433.6	14,226.2	8.94
Номгон сургууль	123,962.1	197,970.8	74,008.8	9.54
Эрдэнэмандал сургууль	216,603.9	259,860.7	43,256.8	12.52
Эрдэм сургууль	67,903.7	174,383.2	106,479.6	8.40
Шаргалжуут сургууль	76,746.7	52,002.3	(24,744.5)	2.51
Баян-Ойт сургууль	90,139.1	75,012.4	(15,126.7)	3.62
Япон сургууль	39,335.3	46,991.4	7,656.1	2.26
1-р цэцэрлэг	89,021.1	88,474.2	(546.9)	4.26
2-р цэцэрлэг	53,714.2	45,314.1	(8,400.1)	2.18
3-р цэцэрлэг	38,665.5	47,207.9	8,542.4	2.28
4-р цэцэрлэг	45,340.3	52,863.9	7,523.6	2.55
5-р цэцэрлэг	61,260.9	46,895.0	(14,365.9)	2.26
6-р цэцэрлэг	73,003.7	82,760.6	9,756.9	3.99
7-р цэцэрлэг	37,998.8	40,964.2	2,965.5	1.97
9-р цэцэрлэг	32,051.6	36,346.0	4,294.4	1.75
10-р цэцэрлэг	56,429.8	53,390.8	(3,038.9)	2.57
11-р цэцэрлэг	43,651.2	42,737.7	(913.6)	2.06
12-р цэцэрлэг	52,914.7	72,109.0	19,194.2	3.48
Шаргалжуут цэцэрлэг	42,666.6	43,048.4	381.8	2.07
13-р цэцэрлэг	38,800.9	66,332.0	27,531.1	3.20
14-р цэцэрлэг	19,161.5	23,880.7	4,719.2	1.15
15-р цэцэрлэг	27,872.8	40,272.7	12,399.8	1.94
16 цэцэрлэг	76,728.9	101,507.7	24,778.8	4.89
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,737,217.7</b>	<b>2,074,869.8</b>	<b>337,652.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 1,873,574.6 мянган төгрөгийн бараа материалын 1,709,727.5 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 7,769.0 төгрөгийн

материал хандиваар, 151,598.2 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан, 4,479.9 мянган төгрөгийн материал дотоод шилжүүлэг болоод бусад хэлбэрээр авсан байна.

Хандиваар авсан 7,769.0 мянган төгрөгийн материалын 3,304.0 мянган төгрөгийн бараа материалыг Номундалай цогцолбор сургуульд, 685.0 мянган төгрөгийн бараа материалыг 5-р цэцэрлэгт эцэг эхчүүдээс тус тус хандивласан 3,780.0 мянган төгрөгийн бараа материалыг 2-р сургуульд Дэлхийн Зөн Монгол ОУБ болоод бусад төсөл арга хэмжээгээр ариутгалын бодис үнэ төлбөргүй нийлүүлснийг бүртгэсэн байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	1,873,574.6	Хасагдсан	1,535,922.5
Худалдан авсан	1,709,727.5	Худалдсан, зарцуулсан	1,259,919.2
Хандиваар	7,769.0	Шилжүүлсэн	37,591.2
Шилжүүлэн авсан	151,598.2	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	-
Бусад	4,479.9	Бусад	238,412.1

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 34872316.2 мянга, эцсийн үлдэгдэл 39351560.5 мянган төгрөг болж, 4479244.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	<b>30,620,694.6</b>	<b>35,101,082.1</b>	<b>4,480,387.5</b>
Барилга байгууламж, орон сууц	25,938,599.9	29,457,101.2	3,518,501.3
Тээврийн хэрэгсэл	241,870.8	255,061.6	13,190.9
Машин тоног төхөөрөмж	2,320,371.3	2,893,223.5	572,852.2
Тавилга эд хогшил	1,655,662.9	1,982,913.9	327,250.9
Түүх соёлын дурсгалт зүйл	194.7	194.7	-
Номын фонд	199,897.5	221,589.6	21,692.2
Бусад үндсэн хөрөнгө	264,097.6	290,997.6	26,900.0
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>4,251,621.6</b>	<b>4,250,478.4</b>	<b>(1,143.2)</b>
Программ хангамж	31,403.6	30,485.4	(918.2)
Бусад биет бус хөрөнгө	4,220,218.0	4,219,993.0	(225.0)
<b>НИЙТ ДҮН</b>	<b>34,872,316.2</b>	<b>39,351,560.5</b>	<b>4,479,244.3</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 4479244.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 16 дугаар цэцэрлэгийн барилга, Соогоо сейко сургуулийн спорт заал, Засаг даргын тамгын газрын хөрөнгөд аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардлын санхүүжилтээр худалдан авсан Номгон, Рашаант багийн барилгыг бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ИТХ	63,997.2	75,310.2	11,313.0
ЗДТГ	1,533,325.1	1,980,583.2	447,258.0
Шаргалжуут ТЗА	337,050.1	337,050.1	-
ЭМТ	1,275,392.8	1,277,692.8	2,300.0
Номун далай сургууль	3,007,086.7	3,265,871.2	258,784.5
Номгон сургууль	3,576,551.7	3,692,310.8	115,759.1
Эрдэнэмандал сургууль	4,421,146.4	4,638,759.6	217,613.1
Эрдэм сургууль	2,717,377.6	2,831,690.3	114,312.7
Шаргалжуут сургууль	636,060.5	678,103.4	42,043.0
Баян-Ойт сургууль	2,234,201.1	2,264,237.9	30,036.8
Япон сургууль	1,026,980.2	1,453,586.3	426,606.1
1-р цэцэрлэг	1,409,769.8	1,419,622.1	9,852.2
2-р цэцэрлэг	578,642.5	587,992.3	9,349.8

3-р цэцэрлэг	791,313.4	806,561.9	15,248.5
4-р цэцэрлэг	788,655.7	799,724.1	11,068.4
5-р цэцэрлэг	883,906.7	1,474,053.1	590,146.5
6-р цэцэрлэг	1,597,444.3	1,611,712.3	14,268.0
7-р цэцэрлэг	700,955.5	712,680.3	11,724.8
9-р цэцэрлэг	591,798.0	602,765.5	10,967.4
10-р цэцэрлэг	2,174,871.4	2,183,433.7	8,562.3
11-р цэцэрлэг	866,969.5	903,338.0	36,368.5
12-р цэцэрлэг	555,959.2	568,929.0	12,969.8
Шаргалжуут цэцэрлэг	1,248,998.6	1,277,030.2	28,031.6
13-р цэцэрлэг	560,405.8	565,654.3	5,248.5
14-р цэцэрлэг	378,713.8	392,022.3	13,308.5
15-р цэцэрлэг	833,161.5	857,935.4	24,773.8
16 цэцэрлэг	81,581.0	2,092,910.3	2,011,329.3
<b>НИЙТ ДҮН</b>	<b>34,872,316.2</b>	<b>39,351,560.5</b>	<b>4,479,244.3</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант Баян-ойт, Соогоо сейко сургуульд тус бүр 1,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий номыг “Мөнхийн Үсэг” ХХК-аас, Номундалай цогцолбор сургуульд 44,545.4 мянган төгрөгийн хөрөнгийг шинэ хичээлийн байр ашиглалтад орсонтой холбоотой эцэг эхчүүд, аж ахуй нэгж, иргэдээс, 5-р цэцэрлэг 3,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг эцэг эхчүүдээс, Номгон ахлах сургуульд 1,311.2 мянган төгрөгийн хөрөнгийг “Дэлхийн зөн Монгол” ОУБ-аас тус тус үнэ төлбөргүй нийлүүлснийг санхүүгийн тайланд хандиваар бүртгэсэн байна.

Дээд шатны байгууллагаас нийт 3,432,701.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан ба тайлант онд нийт 158,734.0 мянган төгрөгийн нийт өртөгтэй 30,655.8 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийн акталсан байна.

*Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Худалдан авсан	569,314.9	Хасагдсан	158,734.0
Хандиваар	51,356.6	Худалдсан	0.0
Шилжүүлэн авсан	3,432,701.4	Акталсан	158,734.0
Бусад	584,605.4	Бусад	0.0
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	Дахин үнэлгээний хорогдол	0.0

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 13172.1 мянга, эцсийн үлдэгдэл 3737.9 мянган төгрөг болж 9434.1 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	<b>13,172.1</b>	<b>3,737.9</b>	<b>-9,434.1</b>	<b>100.0</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	7,253.0	2,764.1	-4,488.9	73.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,856.6	179.7	-1,676.9	4.8
Байгууллагад төлөх өглөг	3,796.1	118.8	-3,677.3	3.2
Хувь хүмүүст төлөх өглөг	266.4	675.3	409.0	18.1
<b>Дүн</b>	<b>13,172.1</b>	<b>3,737.9</b>	<b>-9,434.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2764.1 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой, 179.7 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын, хувь хүмүүст болон байгууллагад төлөх, 794.1 мянган төгрөгийн бусад өглөг байгаа ба Номгон, Эрдэм ахлах сургууль, 13, 15 дугаар цэцэрлэгийн ажиллагсадтай холбоотой 2642.1 мянга, өглөг Засаг даргын тамгын газрын 456.1 мянган төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг байгаа нь гол нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	-	456.1	456.1	12.2
Шаргалжуут тосгон	-	159.1	159.1	4.3
Эрүүл мэндийн төв	23.1	-	(23.1)	-
Орон нутгийн хөгжлийн сан	784.5	-	(784.5)	-
Сум хөгжүүлэх сан	137.4	-	(137.4)	-
Номун далай сургууль	362.2	319.4	(42.8)	8.5
Номгон сургууль	-	1,596.2	1,596.2	42.7
Эрдэм сургууль	659.1	277.0	(382.1)	7.4
Баян-Ойт сургууль	3,830.5	4.4	(3,826.1)	0.1
1-р цэцэрлэг	22.5	22.5	-	0.6
2-р цэцэрлэг	378.4	-	(378.4)	-
3-р цэцэрлэг	4,906.1	-	(4,906.1)	-
5-р цэцэрлэг	-	20.5	20.5	0.5
9-р цэцэрлэг	366.7	-	(366.7)	-
10-р цэцэрлэг	-	101.5	101.5	2.7
13-р цэцэрлэг	300.0	302.5	2.5	8.1
15-р цэцэрлэг	1,401.8	478.8	(923.0)	12.8
<b>НИЙТ ДҮН</b>	<b>13,172.08</b>	<b>3,737.93</b>	<b>(9,434.14)</b>	<b>100.00</b>

**3.5.9 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 33764455.2 мянга, эцсийн үлдэгдэл 37445630.4 мянган төгрөг болж, 3681175.2 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,217,149.8	14,217,149.8	-	38.0
Өмч: - төрийн	14,217,149.8	14,217,149.8	-	38.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,838,847.0</b>	<b>10,525,620.6</b>	<b>3,686,773.6</b>	<b>28.1</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,708,458.4	12,702,859.9	(5,598.4)	33.9
<b>Дүн</b>	<b>33,764,455.18</b>	<b>37,445,630.35</b>	<b>3,681,175.18</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Баянхонгор сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 37445630.3 мянган төгрөг болж 3681175.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 3686773.6 мянган төгрөгийн өсөлт, 5598.4 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 12702859.9 мянган төгрөг болж 5598.4 мянган төгрөгөөр буурсан Засаг даргын тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй 5 дугаар багийн барилгыг акталсантай холбоотой байна.

**3.5.10 Орлогын данс**

Сумын ИТХ-ын 2019.12.13-ний өдрийн хуралдаанаар 14/23 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 1503000.0 мянга, хүү торгуулийн орлогыг 100000.0 мянга, нийт 1603000.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.09.25-ны өдрийн 15/28 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 96294.1 мянган төгрөгөөр хасаж тодотгон татварын орлогыг 1486220.4 мянга, хүү торгуулийн орлогыг 20485.5 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Татварын орлого</b>	<b>1,486,220.4</b>	<b>1,645,711.1</b>	<b>159,490.7</b>	<b>10.7</b>
1.1.ИОТХ	297,180.0	327,618.5	30,438.5	10.2
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	603,912.4	613,150.9	9,238.5	1.5
1.3. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	50,000.0	114,037.6	64,037.6	128.1
1.4.Бууны татвар	6,000.0	6,355.0	355.0	5.9
1.5.Улсын тэмдэгтийн хураамж	13,128.0	14,273.0	1,145.0	8.7
1.6.Ус рашаан ашигласны төлбөр	-	11,498.1	11,498.1	
1.7.Газрын төлбөр	26,000.0	30,348.2	4,348.2	16.7
1.8.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	490,000.0	523,430.0	33,430.0	6.8
1.9. ТТАМАТөлбөр	-	5,000.0	5,000.0	
<b>2.Татварын бус орлого</b>	<b>20,485.5</b>	<b>82,832.1</b>	<b>62,346.6</b>	<b>304.3</b>
2.1.Хүү торгуулийн орлого	20,485.5	82,832.1	62,346.6	304.3
<b>Нийт дүн</b>	<b>1,506,705.9</b>	<b>1,728,543.2</b>	<b>221,837.3</b>	<b>14.7</b>

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 159490.7 мянга, хүү торгуулийн орлогыг 62346.6 мянга, нийт 62346.6 мянган төгрөгөөр орлогын бүх нэр төрлөөр давуулан биелүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019.12.13-ний өдрийн хуралдаанаар 14/23 дугаар тогтоолоор сумын ЗДТГ, Шаргалжуут тосгоны захирагчийн ажлын алба, Номгон, Номундалай, Эрдэм, Эрдэнэмандал сургуулийн өөрийн орлогыг нийт 69860.0 мянган төгрөгөөр төлөвлөж, сумын ИТХ-ын 2020.09.25-ны өдрийн хуралдааны 15/28 дугаар тогтоолоор Номгон, Номундалай, Эрдэм, Эрдэнэмандал сургуулийн өөрийн орлогыг 38960.0 мянган төгрөгөөр хасч тодотгосон бөгөөд гүйцэтгэлээр ЗДТГ 5790.6 мянга, Шаргалжуут тосгон 8400.0 мянга, Номгон 9000.0 мянга, Номундалай 11000.0 мянга, Эрдэм 450.0 мянган төгрөг нийт 34640.6 мянган төгрөгийн орлого оруулсныг тайланд бүртгэжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 177769.9 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 356960.6 мянган төгрөгийн орлогыг оруулсан бол ОНХС-д өвс тэжээл, малын ашиг долооцын орлогоор 729.3 мянган төгрөг орсныг орлогоор бүртгэж тайлагнасан байна

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 22651307.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 21721013.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 21446585.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 274428.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 26 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба шинээр ашиглалтад орсон 16 дугаар цэцэрлэг ба ашиглалтад орохоор хүлээгдэж буй 5 дугаар сургуулийн төсвийн төслийг хүргүүлээгүй ч сумын ИТХ-ын 2019.12.13-ний өдрийн 14/23 дугаар тогтоолоор нийт 25961.2 мянган төгрөгийг баталсан байна.

**Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/**

Байгууллагын нэр	Төсвийн төсөл	Анхны батлагдсан төсвийн дүн	Зөрүү	Байгууллагын нэр	Төсвийн төсөл	Анхны батлагдсан төсвийн дүн	Зөрүү
Номгон ахлах сургууль	2,913,076.5	2,829,244.2	(83,832.3)	4-р цэцэрлэг	433,707.7	382,971.1	(50,736.6)
Номундалай цогцолбор сургууль	4,006,449.6	3,922,152.7	(84,296.8)	5-р цэцэрлэг	562,598.3	673,281.5	110,683.2
Эрдэм ахлах сургууль	1,681,271.4	1,864,194.5	182,923.1	6-р цэцэрлэг	611,667.6	606,191.6	(5,476.0)
Эрдэнэмандал ахлах сургууль	2,149,557.4	2,359,138.2	209,580.8	7-р цэцэрлэг	500,778.1	497,753.2	(3,024.9)
Шаргалжуут сургууль	509,504.4	516,878.5	7,374.1	9-р цэцэрлэг	297,174.4	309,121.6	11,947.2
Баян-ойт бага сургууль	645,013.0	802,769.3	157,756.3	13-р цэцэрлэг	342,339.7	345,217.0	2,877.3
Соогоо- Сейко бага сургууль	1,017,223.6	879,641.0	(137,582.6)	Шаргалжуут цэцэрлэг	278,013.6	280,111.7	2,098.1
10-р цэцэрлэг	496,339.9	631,514.4	135,174.5	Баянхонгор сум 16-р цэцэрлэг	-	845,639.4	845,639.4
11-р цэцэрлэг	414,405.9	476,139.6	61,733.7	5-р сургууль	-	2,056,109.3	2,056,109.3
12-р цэцэрлэг	454,626.1	442,635.6	(11,990.5)	Шаргалжуут эмнэлэг	318,471.0	318,470.8	(0.2)
14-р цэцэрлэг	461,399.5	291,270.1	(170,129.4)	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	202,672.3	249,083.9	46,411.6
15-р цэцэрлэг	364,249.0	347,849.4	(16,399.6)	Засаг даргын тамгын газар	994,975.0	1,612,370.3	617,395.3
1-р цэцэрлэг	660,493.5	755,364.7	94,871.2	Шаргалжуут тосгон	63,269.7	58,315.1	(4,954.6)
2-р цэцэрлэг	220,944.1	395,528.1	174,584.0	Сум хөгжилэх сан	-	418,420.0	418,420.0
3-р цэцэрлэг	344,782.4	490,461.4	145,679.0	Орон нутгийн хөгжлийн сан	-	303,396.4	303,396.4
<b>НИЙТ ДҮН</b>					<b>20,945,003.6</b>	<b>25,961,234.6</b>	<b>5,016,231.0</b>

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардал сумын ИТХ-ын 2019.12.13-ний өдрийн 14/23 дугаар тогтоолоор анх баталсан 25961234.6 мянган төгрөгийг 2020.09.25-ний өдрийн 15/28 дугаар тогтоолоор 1674653.3 мянган төгрөгөөр бууруулж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 317893.6 мянга, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 1196964.8 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 22771722.9 мянган төгрөг болжээ.

Харин шинээр ашиглалтад орохоор хүлээгдэж буй 5 дугаар сургуулийн тогтмол зардал 120415.1 мянган төгрөгийг хасаж тодотгоогүй байгаа ч тус сумын санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдээгүй аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хувийн сургууль гэсэн ангиллаар нэгтгэгдэхээр Засгийн газрын удирдлага мэдээллийн системд бүртгэгдсэн тул тус дүнг хасаж сумын нийт батлагдсан төсвийг 22651307.8 мянган төгрөгөөр нэгтгэсэн болно.

Нийт зардлын 17248833.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 14247.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 258331.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 3154092.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 1506705.9 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 208669.9 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 380842.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 16961.4 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 764.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу, мөн аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 5 дугаар сургуулийн тогтмол зардал 120415.1 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

**Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/**

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1-р сургууль	3,874,897.40	3,784,178.67	90,718.73	97.7
1-р цэцэрлэг	659,797.80	654,195.42	5,602.38	99.2
10-р цэцэрлэг	532,479.60	508,352.87	24,126.73	95.5
11-р цэцэрлэг	436,537.40	429,480.85	7,056.55	98.4
12-р цэцэрлэг	385,695.80	380,322.81	5,372.99	98.6
13-р цэцэрлэг	352,547.30	349,911.79	2,635.51	99.3
14-р цэцэрлэг	275,082.10	272,260.40	2,821.70	99.0
15-р цэцэрлэг	367,331.50	355,640.76	11,690.74	96.8
16-р цэцэрлэг	724,742.90	717,683.22	7,059.68	99.0
2-р сургууль	2,761,320.60	2,706,072.20	55,248.40	98.0
2-р цэцэрлэг	352,641.20	348,366.79	4,274.41	98.8
3-р сургууль	2,216,969.90	2,184,433.31	32,536.59	98.5

**Баянхонгор сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

3-р цэцэрлэг	433,240.20	422,927.98	10,312.22	97.6
4-р сургууль	1,909,735.40	1,782,703.41	127,031.99	93.3
4-р цэцэрлэг	334,298.30	328,143.92	6,154.38	98.2
5-р цэцэрлэг	598,351.40	592,642.82	5,708.58	99.0
6-р цэцэрлэг	514,080.80	502,032.59	12,048.21	97.7
7-р цэцэрлэг	420,832.00	408,864.65	11,967.35	97.2
8-р цэцэрлэг	231,598.30	220,756.56	10,841.74	95.3
9-р цэцэрлэг	297,931.30	289,936.55	7,994.75	97.3
Баян-ойт сургууль	775,872.40	760,200.49	15,671.91	98.0
Засаг даргын тамгын газар	1,641,869.60	1,577,064.73	64,804.87	96.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	245,839.80	243,480.88	2,358.92	99.0
Сум хөгжүүлэх сан	294,024.50	1,383.50	292,641.00	0.5
Шаргалжуут сургууль	510,830.90	437,570.00	73,260.90	85.7
Шаргалжуут тосгон Захирагчийн ажлын алба	58,315.10	54,635.11	3,679.99	93.7
Шаргалжуут эмнэлэг	318,470.80	314,664.23	3,806.57	98.8
Япон сургууль	838,701.90	818,678.45	20,023.45	97.6
Орон нутгийн хөгжлийн сан	287,271.60	274,428.24	12,843.36	95.5
<b>Нийт дүн</b>	<b>22,651,307.80</b>	<b>21,721,013.22</b>	<b>930,294.58</b>	<b>95.9</b>

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21721013.2 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь Засаг даргын Тамгын газрын зардлыг 68484.9 мянга, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын урсгал зардлыг 135667.9 мянга, ерөнхий боловсролын сургуулиудын урсгал зардлыг 405928.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 16. Баянхонгор сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>22,651,307.80</b>	<b>21,721,013.22</b>	<b>930,294.58</b>	<b>95.9</b>
<b>70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага</b>	<b>245,839.80</b>	<b>243,480.88</b>	<b>2,358.92</b>	<b>99.0</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	213,590.20	211,241.90	2,348.30	98.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	700.00	700.00	-	100.0
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	26,384.60	26,373.97	10.63	100.0
82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийл	5,165.00	5,165.00	-	100.0
<b>70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>1,700,184.70</b>	<b>1,631,699.84</b>	<b>68,484.86</b>	<b>96.0</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	647,856.80	619,677.50	28,179.30	95.7
80106 Баг, хорооны ҮАЗардал	334,633.90	295,332.24	39,301.66	88.3
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,500.00	4,290.00	210.00	95.3
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	90,500.00	89,729.32	770.68	99.1
82212 Хур хог хаягдал, орчны бохирдол	553,694.00	553,694.00	-	100.0
83201 Ангилалдаагүй бусад зориулалт,	69,000.00	68,976.78	23.22	100.0
<b>70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт</b>	<b>287,271.60</b>	<b>274,428.24</b>	<b>12,843.36</b>	<b>95.5</b>
80904 Нийгмийн зориулалттай барилга	287,271.60	274,428.24	12,843.36	95.5
<b>71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>	<b>318,470.80</b>	<b>314,664.23</b>	<b>3,806.57</b>	<b>98.8</b>
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	24,724.30	24,724.13	0.17	100.0
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	12,519.70	12,118.10	401.60	96.8
81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлч	281,226.80	277,822.00	3,404.80	98.8
<b>71801 Сургуулийн өмнөх боловсрол</b>	<b>6,917,187.90</b>	<b>6,781,520.00</b>	<b>135,667.90</b>	<b>98.0</b>
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	9,883.30	9,664.64	218.66	97.8
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	1,029,454.70	1,005,639.52	23,815.18	97.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	7,185.70	6,645.80	539.90	92.5
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	437,185.80	437,418.26	(232.46)	100.1
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	4,993,068.00	4,946,350.24	46,717.76	99.1
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	440,410.40	375,801.53	64,608.87	85.3

<b>71802 Ерөнхий боловсрол</b>	<b>12,806,254.00</b>	<b>12,400,325.26</b>	<b>405,928.74</b>	<b>96.8</b>
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	11,281.20	10,862.50	418.70	96.3
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	1,786,727.20	1,747,162.12	39,565.08	97.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	26,840.80	26,594.03	246.77	99.1
81801 үдийн цай хөтөлбөр	390,984.10	219,478.50	171,505.60	56.1
81806 Дотуур байрны үйлчилгээ	256,044.50	198,587.53	57,456.97	77.6
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	8,424,482.20	8,322,103.84	102,378.36	98.8
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	1,909,894.00	1,875,536.74	34,357.26	98.2
<b>71806 Насан туршийн болон албан бус боловсрол</b>	<b>82,074.50</b>	<b>73,511.28</b>	<b>8,563.22</b>	<b>89.6</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	82,074.50	73,511.28	8,563.22	89.6
<b>72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих</b>	<b>294,024.50</b>	<b>1,383.50</b>	<b>292,641.00</b>	<b>0.5</b>
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	294,024.50	1,383.50	292,641.00	0.5

Эх сурвалж: :Баянхонгор сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 18 байгууллага 755980.8 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 7 байгууллага 294061.0 мянга, нийт 1050041.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 424512.6 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 34315.3 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 211870.1 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 362757.9 мянга, нийт 1033455.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 16585.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.  
Хүснэгт 17. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	8	4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл,
2	Хагас жил	3	3	3	-	
3	Улирал бүр	2	8	8		Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1 дүгээр улиралд

4	Сар бүр	5	60	59	1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 12 дугаар сард хоцроосон.
5	Тухай бүр	6	72	63	9	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг 2, 5 дугаар сард, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 5, 12 дугаар сард, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг 5 дугаар сард хоцроосон.
<b>НИЙТ</b>		30	155	141	14	

Эх сурвалж. Баянхонгор сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байр 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 18* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-			100.0
Нийт	2	-	2	-			100.0

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 27 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 29 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 26 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 санхүүгийн тайланд түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 21, “Хязгаарлалттай” 4 /Эрдэм ахлах сургууль, Баянхонгор сумын 3, 13, 15 дугаар цэцэрлэг/, “Сөрөг” 1 /11 дүгээр цэцэрлэг/ дүгнэлт өгсөн байна.

*Хүснэгт 19. Хязгаарлалттай болон Сөрөг дүгнэлт авсан байгууллагууд*

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
<b>"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"</b>	
<b>БАЯНХОНГОР СУМЫН ЭРДЭМ АХЛАХ СУРГУУЛЬ</b>	Тус сургуулийн гадна фасадын засварын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо ажил гүйцэтгэх гэрээний 2.1, 2.2 дахь заалтыг зөрчиж ажлын гүйцэтгэлийн баталгаажуулалгүй 44880,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн 2020 оны 12 дугаар сард сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлээд тухайн хөрөнгийг тайлант онд хүлээж аваагүй байж тооллогын бүртгэлд биетээр байгаагаар баталгаажуулсан.

<p><b>БАЯНХОНГОР СУМ 13-Р ЦЭЦЭРЛЭГ</b></p>	<p>Захирал нягтлан бодогч нар нь амралтын цалин болон үр дүнгийн урамшуулал авахдаа 2709,1 мянган төгрөгийг давхардуулан авсан. "Шунхлай трейдинг" ХХК-руу 2020.12.14-нд 1000,0 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч эд хариуцагчийн тайланд замын хуудас байхгүй. Хандив тусламжаар авсан 245,0 мянган төгрөгийн бараа материалыг орлого, зарлагад тусгагдаагүй, тооллого явуулахад агуулахад байхгүй, хүүхдүүдэд тараасан гэх тайлбар өгсөн боловч баримтаар нотлогдохгүй байна. "ДЭВЖИХ БОЛОР" ХХК-нд 12257,1 мянган төгрөг шилжүүлсэн боловч бараа материалыг хүлээн авах акт үйлдээгүй хүлээн авсан эсэх нь тодорхойгүй.</p>
<p><b>БАЯНХОНГОР СУМЫН 15-Р ЦЭЦЭРЛЭГ</b></p>	<p>Байгууллагын даргын 2020 оны 49 дүгээр тушаалаар эд хөрөнгийн тооллогын комиссыг томилсон ч эд хөрөнгийг бүрэн тоолсон эсэхийг нотлох боломжгүй; Байгууллагын нярав сар бүр бараа материалын тайланг гаргаагүй байхад нягтлан бодогч бараа материалын дэлгэрэнгүй болон хураангуй журнал хөтөлж бүртгэл тайланд тусгасан байна.</p>
<p><b>БАЯНХОНГОР СУМЫН 3-Р ЦЭЦЭРЛЭГ</b></p>	<p>Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 20 ний өдрийн А/45 дугаар тушаалаар тооллогын комиссыг томилсон ч хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодсон баримт байхгүй, тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл нярвын тайлангийн үлдэгдлээс 6117,5 төгрөгөөр зөрүүтэй. Бэлтгэн нийлүүлэгч рүү 5143,0 мянган төгрөг шилжүүлээд бэлнээр гаргуулан авч 3468.0 мянган төгрөгөөр дрож худалдан авсан, 1675.0 мянган төгрөгөөр хүүхдийн шкаф захиалаад хүлээн аваагүй байж санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэсэн.</p>
<p><b>"СӨРӨГ САНАЛ ДҮГНЭЛТ"</b></p>	
<p><b>БАЯНХОНГОР СУМЫН 11-Р ЦЭЦЭРЛЭГ</b></p>	<p>Тайланд онд бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн 15294.4 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан бөгөөд бараа худалдан авсан, урсгал засвар хийлгэсэн эсэх нь тодорхойгүй, нярав орлого аваагүй, анх шатны бүртгэл тайланд тусгагдаагүйгээс нотлох боломжгүй; Бараа материалын тайланд 7020.0 мянган төгрөгийг дрож, 2345.0 мянган төгрөгийн тоглоомын багц орлогод авч бүртгэсэн боловч аудитын тулган баталгаажуулалтаар тухайн хөрөнгүүдийг хүлээн аваагүй мөн дээрх шилжүүлсэн 2345,0 мянган төгрөгийг нийлүүлэгч аж ахуйн нэгжээс мөнгийг бэлнээр авсан болох нь тогтоогдсон; Жилийн эцсийн тооллого хийж тооцоо бодоогүй, хүнсний материалын үлдэгдэл 1069.6 мянган төгрөгийн хүнсийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад буцааж шилжүүлсэн гэх боловч акт үйлдээгүй.</p>

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 423249.8 мянган төгрөгийн 111 алдаа, зөрчил илэрснээс 25038.8 мянган төгрөгийн 20 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 69845.9 мянган төгрөгийн 16 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 307720.0 мянган төгрөгийн 64 зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 20645.1 мянган төгрөгийн 11 алдааг санхүүгийн тайланд залруулжээ. /Хавсралт 2./

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн "БМБМОЖ"-ХХК-аас хөгжим тоглоом худалдан авахаар 6750.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, тухайн хөрөнгөөс 2345.0 мянган төгрөгийн тоглоомын багцыг аудитын явцад үзэхэд аваагүй тус байгууллагаас бэлэн мөнгийг гаргуулж авсан, "Дэлгэрэх Их богд" ХХК-аас 7020000 төгрөгөөр дрож худалдан авахаар мөнгийг шилжүүлж хөрөнгийг хүлээж аваагүй байхад нягтлан бодогч, нярав хөрөнгийг хүлээн авснаар тайланд тусгасан", нярав Б.Чонцолд байгууллагын бичиг хэргийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа гэж 40 хувийн цалин өгдөг боловч зарим саруудад тухайн цалин дарга, нягтлан бодогч нарт шилжүүлсэн зэрэг зөрчлүүдийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах арга хэмжээ авч биелэлтийг 2021.05.21-ы дотор ирүүлэх албан шаардлага өгч Баянхонгор сумын Засаг дарга Ж.Мөнхсоёл, санхүүгийн албаны дарга Т.Баасансүрэн нарт даалгасан байна.

Аудитаар нийт 115037.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 64571.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 50466.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 3681.8 мянган төгрөгөөр авлагыг дутуу, 9583.0 мянган төгрөгөөр бараа материалыг дутуу, 6454.4 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг хөрөнгийг дутуу, 1596.1 сая төгрөгөөр өр төлбөрийг илүү нийт 21315.3 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 1671.4 мянган төгрөгөөр төсөвт байгууллагын өөрийн орлогыг дутуу, 12668.6 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны зардлыг илүү, 16165.2 мянган төгрөгөөр үйл ажиллагааны үр дүнг илүү, нийт 30505.2 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 12270.5 мянган төгрөгөөр нийт орлогыг дутуу, 480.0 мянган төгрөгөөр бараа үйлчилгээний зардлыг илүү, нийт 12750.5 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;

#### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр Баянхонгор сумын Санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

#### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ**

**3.1.1. Илрүүлэлт:** Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд орлого, зарлагын төрлийг 50466.1 мянган төгрөгөөр буруу тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийж 4 байгууллага “Хязгаарлалттай”, 1 байгууллага “Сөрөг” дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

**3.1.2. Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих санхүүгийн албаны даргын хяналтыг сайжруулах.

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

### 3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

#### 3.2.2 Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

Бэлтгэсэн: АУДИТОР		Ж.ӨСӨХБАЯР 2021.03.25
Анхан шатанд хянасан: АУДИТЫН МЕНЕЖЕР		А.ЦЭЭНЯМ 2021.03.25
Хоёр дахь шатанд хянасан: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.МӨНХБАТ 2021.03.25

**5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо</b> 2020	<b>Аудитын нэр:</b>	Баянхонгор сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b> БНА-2021/18/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		Баянхонгор сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сумын Засаг даргын үр дүн, мөнгөн гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн тайлангийн өмнөх оны үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн байна.	64571.0	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Ж.Мөнхсоёл, Т.Баасансүрэн
2	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд орлого, зарлагын төрлийг 50466.1 мянган төгрөгөөр буруу тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийж 4 байгууллага "Хязгаарлалттай", 1 байгууллага "Сөрөг" дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	50466.1	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Ж.Мөнхсоёл, Т.Баасансүрэн
3	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Ж.Мөнхсоёл, Т.Баасансүрэн
<b>ДҮН</b>		<b>115037.1</b>			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

**6. Хавсралт 2.: Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт** /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6
1	Баянхонгор сум 13-р цэцэрлэг	Захирал нягтлан бодогч нар нь амралтын цалин болон үр дүнгийн урамшуулал авахдаа 2709,1 мянган төгрөгийг давхардуулан авсан.	2,709.1	Төлбөрийн акт тогтоосон	Эрхлэгч, Нягтлан бодогч	Ц.Оюунчимэг, Х.Одончимэг
2	Баянхонгор сум 13-р цэцэрлэг	Шунхлай трейдинг ХХК-руу 2020.12.14-нд 1000.0 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч эд хариуцагчийн тайланд замын хуудас байхгүй байна.	1,000.0	Албан шаардлага өгсөн	Эрхлэгч, Нягтлан бодогч	Ц.Оюунчимэг, Х.Одончимэг
3	Баянхонгор сум 13-р цэцэрлэг	"ДЭВЖИХБОЛОР" ХХК-нд 2020.12.14 өдөр Норм зөөлөн эдлэлийн зардалаас 1431,0 мянга, Бараа үйлчилгээний зардалаас 6726,0 мянга, Засварын зардалаас 4100,1 мянга, нийт 12257,1 мянган төгрөг шилжүүлсэн боловч бараа материалыг хүлээн авах акт үйлдээгүй хүлээн авсан эсэх нь тодорхой бус байна.	12,257.1	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч, Нягтлан бодогч	Ц.Оюунчимэг, Х.Одончимэг
4	Баянхонгор сумын Орон нутгийн хөгжлийн сан	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллээс хугацаандаа оруулсан 12 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 1 мэдээлэл байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, санхүүгийн албаны дарга	Ж.Мөнхсөөл, Т.Баасансүрэн
5	Баянхонгор сум Сум хөгжүүлэх сан	Шилэн дансны мэдээлэлд 1323.5 төгрөг дупу сэдээлсэн	-	Зөвлөмж өгсөн	Засан дарга, нягтлан бодогч	Ж.Мөнхсөөл, Б.Даваажаргал
